



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2026 оны 05 сарын 22 өдөр

Дугаар А/379

Булган сум

┌ Аэродром орчмын аюулгүйн бүс ┐ тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Иргэний нисэхийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2 дахь заалт, Зам тээврийн сайдын “Техникийн баримт бичгийг шинэчлэн батлах тухай” 2025 оны А/275 тоот тушаалаар батлагдсан “Аэродромын төлөвлөлт ба ашиглалт” техникийн баримт бичгийн 11.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Булган аймгийн Булган сумын нутагт орших Иргэний нисэхийн үндэсний төв ТӨХХК-ны харьяа “Булган” нисэх буудлын аэродромын орчмын аюулгүйн бүс болох “Тусгай бүс”, “Агаарын хөлгийн ойртолтын бүс”, “А” болон “Б” бүсийн зургийг 1 дүгээр хавсралтаар, хязгаарын цэгийн солбицлуудыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Аэродромын аюулгүйн “Тусгай бүс” буюу агаарын хөлгийн буулт, хөөрөлтийн чиглэлд хөөрч буух зурвасын босгоос хоёр тийш 4000 метр урт, хөөрч буух зурвасын голчоос хоёр тийш 1000 метр буюу нийт 2000 метрийн өргөнтэй тэгш өнцөгт талбайд Иргэний нисэхийн зориулалттайгаас бусад зориулалттай газар олгохгүй байх, өмнө олгогдсон газарт барилга байгууламж барих тохиолдолд Иргэний нисэхийн ерөнхий газар, Нисэх буудалтай урьдчилан зөвшилцөж, нисэхийн аюулгүй байдлыг хангасан шийдвэр гаргаж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т даалгасугай.

3.Аэродром орчмын “Аюулгүйн А болон Б бүс”-д иргэн, аж ахуйн нэгжийн явуулж буй үйл ажиллагаа нь “Аэродромын төлөвлөлт ба ашиглалт” техникийн баримт бичгийн 11.1-ийг хангаж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллахыг Булган сумын Засаг дарга (Д.Бямбажаргал), Бугат сумын Засаг дарга (Х.Ууганбаяр), Булган нисэх буудал (Д.Очирбат)-д тус тус үүрэг болгосугай.

4.Аэродромын “Тусгай бүс”-ийг тэмдэгжүүлж ажиллахыг Булган нисэх буудал (Д.Очирбат)-д даалгасугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг даргын тамгын газар (Д.Эрдэнэбилэг), Аймгийн Засаг даргын тамгын газрын Салбарын хяналт, зохицуулалтын хэлтэс (Г.Давааням), Булган нисэх буудал (Д.Очирбат)-д тус тус даалгасугай.

6.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Аймгийн Засаг даргын 2021 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн А/147 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА




Д.ПҮРЭВ-ОЧИР

Аймгийн Засаг даргын 2026 оны
05 дугаар сарын 22 ны/ний өдрийн
А/379 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт



АЭРОДРОМ ОРЧМЫН АЮУЛГҮЙН БҮСИЙН ЗУРАГ



Аймгийн Засаг даргын 2026 оны
05 дугаар сарын 22-ны/ний өдрийн
А/329 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт



**АЭРОДРОМ ОРЧМЫН АЮУЛГҮЙН БҮСИЙН
ХЯЗГААРЫН ЦЭГИЙН СОЛБИЦОЛ**

1. “Аэродром орчмын аюулгүйн тусгай бүс”-ийн газарзүйн солбицол

д/д	X	Y	Нэршил
1	2	3	4
1	5416424.8916	384888.1664	Аэродром орчмын тусгай бүс
2	5410195.4749	392605.7175	
3	5408637.8020	391351.2958	
4	5414867.2188	383633.7448	

2. “Аэродромын ойртолтын бүс”-ийн газарзүйн солбицол

д/д	X	Y	Нэршил
1	2	3	4
1	5418378.0698	376128.0962	Аэродром ойртолтын бүс
2	5422994.9431	379842.2164	
3	5413154.5967	387387.4125	
4	5413115.6630	387356.0412	
5	5411909.5422	388850.2900	
6	5411948.4844	388881.6509	
7	5406686.3128	400109.7867	
8	5402069.4395	396395.6665	

**3. “Аэродром орчмын аюулгүйн А бүс”- Аэродромын хяналтын цэгт
төвтэй 3 км радиустай тойрог**

д/д	Аэродромын хяналтын цэг	Нэршил
1	2	3
1	485120N 1032829E	Аэродром орчмын аюулгүйн А бүс Аэродромын хяналтын цэгт төвтэй 3 км радиустай тойрог

**4. “Аэродром орчмын аюулгүйн Б бүс”- Аэродромын хяналтын цэгт
төвтэй 8 км радиустай тойрог**

д/д	Аэродромын хяналтын цэг	Нэршил
1	2	3
1	485120N 1032829E	Аэродром орчмын аюулгүйн Б бүс Аэродромын хяналтын цэгт төвтэй 8 км радиустай тойрог

--o0o--